



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/241

Хэрлэн сум

Алтан цом-2025 спортын наадамд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хот дахь Хэнтий аймгийн Залуучуудын холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Алтан цом-2025 спортын наадмыг зохион байгуулах зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Үндэсний спорт болон их спортын наадам, тэмцээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ